ШИФР : 07/20

А0305 ДУГААРТАЙ УЛСЫН ЧАНАРТАЙ ХОВД - БАЯН-ӨЛГИЙ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХОВД СУМ ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ 18.755км АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

БОТЬ-2/8

ТАЙЛБАР БИЧИГ

УЛААНБААТАР 2020

"ЭМ СИ ПИ СИ ЖИ АР"ХХК

ШИФР : 07/20

А0305 ДУГААРТАЙ УЛСЫН ЧАНАРТАЙ ХОВД - БАЯН-ӨЛГИЙ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХОВД СУМ ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ 18.755км АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

ТАЙЛБАР БИЧИГ

ЗАХИРАЛ ..... /Б. АНАНДА/

ИНЖЕНЕР ..... /Д. ЧИНТҮШИГ/

Зураг төслийг хянасан
ЭКСПЕРТ № .....
..... он ..... сар
Засварлаж эхэлсэн ..... өдөр
ЗАМ, ТЭЭВЭР, ГҮҮРИЙН ЯАМ

УЛААНБААТАР 2020

No.	ЗУРГИЙН ИЖ БҮРДЭЛ	ДУГААР	ТАЙЛБАР
1	А0305 ДУГААРТАЙ УЛСЫН ЧАНАРТАЙ ХОВД - БАЯН-ӨЛГИЙ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХОВД СУМ ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ 18.755км АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ	Боть-1/8	"МСРС"gr ХХК 07/20 2020 он
2	ТАЙЛБАР БИЧИГ	Боть-2/8	
3	ТЕХНИКИЙН ШААРДЛАГА	Боть-3/8	
4	БАРУУН БОСОО ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХОВД АЙМГИЙН ХОВД СУМ ХҮРТЭЛХ АВТО ЗАМЫН ЗУРАГ ТӨСЛИЙН АЖЛЫН ГЕОДЕЗИЙН ХЭМЖИЛТ, ЗУРАГЛАЛЫН АЖЛЫН ТАЙЛАН	Боть-4/8	"ЭРИН кадастр" ХХК 2020 он
5	ХОВД АЙМАГ. ХОВД СУМЫН ТӨВ ХҮРТЭЛХ 18.7КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕР-ГЕОЛОГИЙН СУДАЛГААНЫ АЖЛЫН ТАЙЛАН	Боть-5/8	"БИГС" ХХК ШИФР:ЗТ12-1833/17 2020 он
6	ХОВД АЙМАГ. ХОВД СУМ ЧИГЛЭЛД ШИНЭЭР БАРИГДАХ 18.7 КМ ХАТУУ ХУЧИЛТТАЙ АВТО ЗАМЫН ТРАССТ ОРСОН ХОЛБООНЫ ШИЛЭН КАБЕЛ ХАМГААЛАХ БОЛОН ШИЛЖҮҮЛЭХ АЖЛЫН ЗУРАГ (ГАДНА ХОЛБОО)	Боть-6/8	"АРБЭЛ_АЛТАЙ" ХХК ШИФР:АБ_А21/08-20-ГХ 2020 он
7	А0305 ДУГААРТАЙ УЛСЫН ЧАНАРТАЙ ХОВД-БАЯН-ӨЛГИЙ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХОВД СУМ ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ 18.755 КМ АВТО ЗАМЫН ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ (ЦДАШугам зөөх)	Боть-7/8	"АСЛААН" ХХК ЕГ 28/2020 2020 он
8	А0305 ДУГААРТАЙ УЛСЫН ЧАНАРТАЙ ХОВД - БАЯН-ӨЛГИЙ ЧИГЛЭЛИЙН АВТО ЗАМААС ХОВД СУМ ЧИГЛЭЛИЙН ХАТУУ ХУЧИЛТТАЙ 18.755км АВТО ЗАМЫН АЖЛЫН НЭГДСЭН ТӨСӨВ	Боть-8/8	"МСРС"gr ХХК 07/20 2020 он

	ГАРЧИГ	ХУУДАС
	НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА	2
1.1	Оршил	2
1.2	Зураг төсөл боловсруулах үндэслэл	2-3
1.3	Зураг төсөлд ашигласан норм, стандартууд	3
1.4	Зураг төслийн товч танилцуулга, бүрэлдэхүүн	4-5
1.5	Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд ба сонголт	5-6
1.6	Өгөгдсөн даалгавар ба биелэлт	7-10
	ХОЁР. ХАЙГУУЛ СУДАЛГАА	11
2.1	Уур амьсгал, цаг уурын нөхцөл байдал	11-12
2.2	Замын өнөөгийн байдал	13-15
2.3	Байр зүйн зураглал	16-20
2.4	Замын дагуух буурь хөрсний судалгаа	20-26
2.5	Ус зүйн судалгаа	26-32
2.6	Инженерийн шугам сүлжээний судалгаа	33
	ГУРАВ. ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ	34
3.1	Замын төсөллөлт	34
	3.1.1. Стандарт шалгуур үзүүлэлтүүд, тооцоот сонголт.	34-35
	3.1.2. Замын гарц, уулзвар төсөллөлт.	35-36
	3.1.3. Зогсоолын талбай төсөллөлт	36
	3.1.4. Төслийн зам ба инженерийн шугам сүлжээний огтлолцол	36
	3.1.5. Төсөллөлтийн хамгийн бага үзүүлэлтүүд.	37
	3.1.6. Трасс сонголт, хэвтээ төсөллөлт.	38-43
	3.1.7. Замын дагуу төсөллөлт.	44-48
	3.1.8. Хөндлөн огтлол, хучлагын хийц.	48-50
	3.1.9. Хучилтын тооцоо	50-52
3.2	Хиймэл байгууламжийн төсөллөлт	53
	3.2.1. Төмөрбетон хоолойн төсөллөлт	53-58
	3.2.2. Хажуугийн шуудуу төсөллөлт	59-60
3.3	Хөдөлгөөн зохион байгуулалт, тоноглол	60-61
3.4	Инженерийн шугам сүлжээний зураг төсөл	61
3.4	Ажлын тоо хэмжээ	62
	3.4.1. Замын ажлын тоо хэмжээ, тодорхойлолт	62-67
	3.4.2. Холбооны кабель шугам шилжүүлэх ажлын тоо хэмжээ, тодорхойлолт	68

	3.4.3. Цахилгааны шугам шилжүүлэх ажлын тоо хэмжээ, тодорхойлолт	69
ХАВСРАЛТУУД		70
1.	Ажлын даалгавар	71-73
	Газрын захирамж	74
	Техникийн нөхцөл	75-79
	Албан тоотууд (ЗТХЯ-ны 2020 оны 06/5659 тоот)	80
	Хөдөлгөөний аюулгүй байдалд хийсэн аудитын дүгнэлт	81
2.	Бусад /магадлалын ерөнхий дүгнэлт, бусад/	

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

1.1. ОРШИЛ

Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын баталсан инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаварын дагуу зам гүүрийн инженерийн зөвлөх үйлчилгээний ‘’MCPCgr’’ ХХК нь 07/20 шифртэй “А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын инженерийн нарийвчилсан зураг” төслийг 2020 оны IV улиралд боловсруулав.

1.2. ЗУРАГ ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ҮНДЭСЛЭЛ

- Азийн хөгжлийн банкны зээлээр санхүүжих “Баруун босоо тэнхлэгийн авто зам хөгжүүлэх төсөл”-ийн хүрээнд
- Хөрөнгийн эх үүсвэр – Азийн хөгжлийн банкны хөрөнгө оруулалт
- Зам, тээврийн хөгжлийн яамны төрийн нарийн бичгийн дарга С.Батболдын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдөр баталсан “А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын инженерийн нарийвчилсан зураг боловсруулах ажлын даалгавар” Дугаар-24/20

Инженерийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын хүрээнд дараах ажлууд хийгдсэн болно. Үүнд:

- Инженер-геодезийн хайгуул судалгааны ажлын тайлан
- Инженер-геологийн хайгуул судалгааны тайлан
- Авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл
- Шугам сүлжээг зөөх, хамгаалах ажлын зураг
- Зам, замын байгууламжийн барилгын ажлын техникийн шаардлага
- Зургийн тайлбар бичиг
- Ажлын нэгдсэн төсөв
- Зураг төслийн иж бүрдэл тус бүрийг баталгаажуулсан магадлалын ерөнхий дүгнэлт
- Замын хэвтээ болон босоо элементийг норм дүрмийн хэм хэмжээнд хүргэн сайжруулах,
- Зам, гүүрийн зурваст орсон болон зам, гүүрийн байгууламжийн дээгүүр болон доогуур хөндлөн өнгөрч байгаа сүлжээний техникийн нөхцлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд шилжүүлэх, засварлах өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардлыг тооцож зураг төсөлд тусгах
- Замын хөдөлгөөний тоноглолыг стандартын дагуу төлөвлөх

- Уулзвар гарц, зогсоолын талбайг хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцлийг харгалзан одоо байгаа гудамж замын сүлжээтэй уялдуулан төлөвлөх

1.3. ЗУРАГ ТӨСЛИЙГ БОЛОВСРУУЛАХАД МӨРДЛӨГӨ БОЛГОСОН НОРМ, СТАНДАРТУУД

Инженерийн нарийвчилсан зураг боловсруулахад Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа дараах БНбД, норм болон стандартуудыг ашиглав. Үүнд:

- Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016,
- Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл АЗУАГН 2.01.01-2004,
- “Авто замын гүүр ба хоолой төсөллөх” БНбД 32-02-12
- “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх” БНбД 22.01.01*/2006/
- Геодезийн ажил БНбД 3.01.03-88
- Хот суурины гудамж зам төлөвлөлт БНбД 32-01-04
- Барилга байгууламжийн буурь суурь БНбД 2.02.01-94,
- Монгол орны инженер-геологийн нөхцлийн зураг М 1:500 000,

1.4. ЗУРАГ ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА, БҮРЭЛДЭХҮҮН

Төслийн зам нь Ховд аймгийн Ховд сумын нутаг дэвсгэрт баригдана. Төлөвлөж буй зам нь Ховд-Баян-Өлгий чиглэлийн А0305 дугаартай авто замын 23.15 дахь км-ээс эхлэн баруун урагш чиглэн Ховд сумын төвийн цементобетон хучилттай замын төгсгөлөөс цааш 73м-т хүрнэ. Зураг 1.4.1-д байршлын тоймыг харуулав.



Зураг 1.4.1. *А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын байршлын тойм*

Төлөвлөж буй замын нийт урт 18.755 км байна. Замын дагууд орц, гарцыг 2 байрлалд, нэг төвшингийн уулзвар 1 цэгт, 2 байрлалд зогсоолын талбай, ус гаргах хоолой 27 цэгт төлөвлөгдсөн болно. Мөн газрын гадаргын онцлог, хөрсний үзүүлэлт зэргийг харгалзан 20.34 км урт хажуугийн шуудууг төлөвлөв. Төлөвлөгдөж буй зам нь цахилгаан дамжуулах агаарын шугамтай 1 цэгт, холбооны шилэн кабельтай 3 цэгт огтлолцох бөгөөд хамгаалалт хийх болон зөөх шаардлагатай хэсгүүдэд ашиглагч байгууллагуудаас техникийн нөхцөлүүдийг гаргуулж, холбоо, цахилгааны шугамын зураг төсөл боловсруулах тусгай

зөвшөөрөл бүхий байгууллагуудаар зураг төслийг хийлгүүлж, магадлалаар баталгаажуулав.

Төсөлд оролцогч байгууллагууд

- *Замын трассын дагуух инженер геологийн судалгаа – "БИГС" ХХК*
- *Байр зүйн судалгаа "Эрин кадастр" ХХК*
- *А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын трасст орсон гадна агаарын цахилгаан шугам зөөх, шилжүүлэх, хамгаалах ажлын зураг төсөл- "АСЛААН" ХХК*
- *А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын трасст орсон холбооны шилэн кабель зөөх, шилжүүлэх, хамгаалах ажлын зураг төсөл - "Арбэл алтай" ХХК*

Зураг төслийн захиалагчийн хүсэлтийн дагуу инженерийн нарийвчилсан зураг төслийн иж бүрдлийг 8 боть болгон багцалсныг хүснэгт 1.4.2-т харуулав.

Хүснэгт 1.4.2

№	*Зургийн иж бүрдэл*	*Ботийн дугаар*
1	А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөл	Боть-1
2	Тайлбар бичиг	Боть-2
3	Техникийн шаардлага	Боть-3
4	Геодезийн тайлан	Боть-4
5	Геологийн тайлан	Боть-5
6	Холбооны шилэн кабель шугамыг зөөх, хамгаалах ажлын зураг	Боть-6
7	Цахилгаан дамжуулах агаарын шугамыг зөөх, хамгаалах ажлын зураг	Боть-7
8	Зам барилгын ажлын нэгдсэн төсөв	Боть-8

1.5. ТӨСӨЛЛӨЛТИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД БА СОНГОЛТ

А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийг "Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016" нормыг баримтлан төсөллөсөн бөгөөд үндсэн үзүүлэлтүүдийг хүснэгт 1.5.1-д үзүүлэв.

Хүснэгт 1.5.1. Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд

№	Төсөллөлтийн үндсэн үзүүлэлтүүд	ЗЗБНбД 22-004-2016 нормын үзүүлэлтүүд	Төсөллөлтийн сонгосон үзүүлэлтүүд
1	Замын ангилал ба зэрэглэл	Зэрэглэл 3Б. Хөдөө орон нутгийн, байнгын хөдөлгөөнтэй авто зам	А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто зам
2	Жилийн хоногийн дундаж хөдөлгөөний эрчим	100-аас бага	-
3	Төсөллөлтийн тодорхойлолт	3Б-ХОЗ-БХ-1-40	3Б-ХОЗ-БХ-1-40
4	Тооцоот хурд: Тэгш тал газар	40 км/цаг	40
5	Нугачаатай газар	25 км/цаг	
6	Уулархаг газар	15 км/цаг	
7	Тооцоот хугацаа	10-15 жил	10-15 жил
8	Хөдөлгөөний үйлчилгээний төвшин	D,E	E
9	Трассын шулуун хэсгийн хамгийн их урт	3500м	1546.7
10	Хамгийн их дагуу налуу: Тэгш тал газар	<7%	<4.7%
11	Хамгийн их дагуу налуу: Нугачаатай газар	<11%	
12	Хамгийн их дагуу налуу: уулархаг газар	<13%	
13	Зорчих зурвасын өргөн	7.0-8.0м	7.0м; 8.0м;
14	Хөдөлгөөний зурвасын хучилтын өргөн	4.0м	4.0м
15	Хөвөөний өргөн	1.0-2.0м	1.50м; 2.0м
16	Үүнээс хучилттай хөвөөний өргөн	0.25-0.5м	0.25м
17	Зогсох үеийн хамгийн бага үзэгдэх зай	50м	90м
18	Гүйцэж түрүүлэх үеийн хамгийн бага үзэгдэх зай	140м	150м
19	Хучилтын хөндлөн налуу	2%	2%

1.6. ӨГӨГДСӨН ДААЛГАВАР БА БИЕЛЭЛТ

Зураг төсөл зохиох үе шат, хугацаа: Нарийвчилсан зураг төслийг 2021 оны 1 дүгээр сард багтаан гүйцэтгэх,

- ✓ Нарийвчилсан зураг төслийг 2020 оны 12 сард боловсруулж, 2021 оны 1 дүгээр сарын 11-ний 03/2021 магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажуулсан.

Зураг төслийн иж бүрдэл

"Авто зам төсөллөх" ЗЗБНбД 22-004-2016-ийн хавсралт 2-8-ыг баримтлана

- ✓ Дээрх хавсралтыг баримтласан.

Инженер геологийн судалгааны ажлын тайлан

- ✓ Боть – 5/8

"Геодези зураг зүйн тухай" хуулийн 6.1.3 дугаар заалт, "Барилга байгууламжийн инженерийн судалгааны нийтлэг үндэслэл" БНбД 11-07-04-ын II хэсэг инженер геодезийн ажил "БНбД 3.01.03-88"-д тавигдах шаардлагын дагуу зураг төслийг боловсруулах

- ✓ Дээрх шаардлагын дагуу зураг төслийг боловсруулсан. Боть – 4/8

Инженерийн нарийвчилсан зураг

- ✓ Боть – 1/8

Хучилтын тооцоо

Ус зайлуулах байгууламжийн тооцоо

Түр зогсоолын зураг төсөл

Ажил гүйцэтгэх аргачлал,

- ✓ Боть – 2/8, Боть 3/8-д тус тус тусгагдсан.

Зургийн тайлбар бичиг

- ✓ Боть – 2/8

Техникийн шаардлага

- ✓ Боть – 3/8

Авто замын трасст орсон шугам сүлжээг шилжүүлэх ажлын зураг төсөл

- ✓ Боть – 6/8, Боть – 7/8

Ажлын нэр төрөл, тоо хэмжээ, Барилгын ажлын нэгдсэн төсөв

- ✓ Боть – 8/8

Замын эхлэл Ховд сумын төвийн цементобетон хучилттай замын төгсгөлөөс, замын төгсгөл А0305 Ховд-Өлгий чиглэлийн авто замтай холбох,

- ✓ Авто замын трасс нь Ховд-Баян-Өлгий чиглэлийн А0305 дугаартай авто замын 23.15 дахь км-ээс эхлэн баруун урагш чиглэн Хаалгач уулын урд талын хөндийг гатлан, Шар нуурын урд даваг давж, Дунд усны голын хойгуур явж Ховд сумын

төвийн цементобетон хучилттай замын төгсгөлөөс цааш 73 м-т хүрч төгсөнө. Замын урт 18.76 км.

Төлөвлөж буй авто замын трассыг тус чиглэлд төлөвлөгдсөн авто замын төлөвлөлттэй уялдуулах. ЗТХЯ-ны АЗБХЗГ-тай зөвшилцөх,

- ✓ Төслийн замын трассыг нутаг орны иргэдийн зорчдог одоо байгаа шороон зам болон зураг төсөл боловсруулах ажлын даалгаврын дагуу сонгосон. Энэ нь нэгэнт бий болсон дэд бүтцийн өгөөжийг нэмэгдүүлэх, хөдөлгөөний нэгэнт тогтсон хэв загварыг хадгалах, хөгжүүлэх зэрэг олон үндэслэлтэй болно. ЗТХЯ-ны АЗБХЗГ-т хянуулан, хүлээлгэн өгсөн.

Замын трассын дагуу түр зогсоол байгуулах төлөвлөлтийг зураг төсөлд тусгасан байх,

- ✓ Төслийн хүрээнд тээврийн хэрэгслийн зогсоолын талбайг Монгол улсад мөрдөгдөж буй стандартын дагуу 2 байрлалд тээврийн хэрэгсэл түр зогсох авто зогсоол төлөвлөж, зураг төсөлд тусгасан.

Авто замын чиглэлийг сонгохдоо цас мөсний үйлчлэл, ус дулааны горим, гадаргуун ус зайлуулалт гэх мэтчилэн байгаль цаг уурын хүчин зүйлсийн үйлчлэлийг судалж, орон нутгийн удирдлагатай холбогдох байгууллагаас санал авч, зураг төсөлд тусгах,

- ✓ Замын чиглэлийг сонгохдоо байгаль цаг уур, геологи болон гидрогеологийн байдлыг харгалзан сонголтыг хийж, Ховд аймгийн Ховд сумын удирдлагатай зөвшилцөж, 2020 оны А/261 газрын захирамжийг гаргуулан авсан.

Уулзвар гарцыг төлөвлөхдөө хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах нөхцлийг харгалзан төлөвлөх,

- ✓ Төлөвлөгдөж буй замын эхлэлийн цэгт Ховд - Баян-Өлгий чиглэлийн А0305 авто замаас салаалах хэсэгт хөдөлгөөний дараалыг цэгцтэй зохицуулахад зориулж, хөдөлгөөн зохицуулах арал бүхий уулзвар төлөвлөсөн. Харин орон нутгийн хөрсөн замууд салж, нийлэх 3 байршилд 3 төвт тойрог муруй бүхий орц, гарцыг төсөллөсөн.

Хучилтын хийцийг стандарт, норм норматив, техникийн баримт бичгийг баримтлан, авто замын хөдөлгөөний эрчмийн өнөөгийн болон цаашдын хандлагаар тооцож төлөвлөх,

- ✓ Хучилтын тооцоог “INDOR PAVEMENT 9” программаар хийсэн бөгөөд налархай хотойлт, шилжилсхийлт, гулзайлт, хүйтний овойлт, дугуй мөрний ховил зэрэг үзүүлэлтүүд хангагдаж байх нөхцлийг харгалзан үзэж тооцоог хийв. Мөн ул хөрсний үзүүлэлт, хөлдөлтийн гүн, гүний усны түвшин, хучилтын үеүдэд хэрэглэх материалын үзүүлэлтүүдийг тооцон хучилтын хийцийн үеийн материал болон зузааныг сонгосон болно.

Далангийн өргөн 7.0 м, зорчих хэсгийн өргөн 4.0 м, хөвөөний өргөн 2х1.5 м, үүнээс хөвөөний бэхэлгээтэй хэсэг 2х0.25 м,

- ✓ Замын хөндлөн огтлолын элементүүдийг дараах байдлаар төлөвлөв. Үүнд: замын зорчих хэсгийн өргөн -2.0м*2 ба хөндлөн хэвгий 2.0%, хучилттай хөвөөний өргөн-0.25м*2, хучилтгүй хөвөөний өргөн -1.25мх2 ба налуу 4.0%, нийт далангийн өргөн -7.0 м байхаар тооцсон. Харин замын далан 1.2м-ээс өндөр үед замын хөвөөг 2 тал руу нь 0.5м-ээр өргөтгөж, 8м өргөн даланг төсөллөв.

Хучлагын зузааныг тооцоолж, суурь үеийг буталсан чулуун материалаар хийхээр зураг төсөлд тусгах,

- ✓ Суурийг буталсан чулуун материалаар хийхээр зурагт тусгасан ба тооцоогоор суурийн зузаан 20 см гарсан.

Замын трассын дагуу 2 км тутамд хатуу цэгийг тогтоож, стандартын дагуу бэхлэх, геодезийн хэмжилтийг UTM системд хийж гүйцэтгэх,

- ✓ Шинээр геодезийн байрлал болон өндрийн цэгийн төв болон реперийг Монгол улсын барилгын дүрэм “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” БД11-104-06*/16 дагуу трассын 2 км тутамд суулгасан. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн төрлийг ажлын төрөл, нарийвчлал, газар орчны физик газарзүйн нөхцөл, хөрсний шинж чанарыг харгалзан сонгож, UTM системд хийж гүйцэтгэсэн.

Зам, гүүрийн зурваст орсон болон доогуур хөндлөн өнгөрч байгаа инженерийн байгууламж, цахилгаан, холбооны шугам сүлжээний техникийн нөхцөлийг холбогдох байгууллагуудаас авах, шаардлагатай тохиолдолд нүүлгэн шилжүүлэх, засварлах, өндөрсгөх ажлын тоо хэмжээ, зардлыг тооцож зураг төсөлд тусгах,

- ✓ Цахилгааны шугамын тодруулга болон 2020 оны №85 Техникийн нөхцлийг Ховд аймгийн “Цахилгаан түгээх сүлжээ” ХК-аас, холбооны шилэн кабелийн тодруулга, 2020 оны №ТН24-14/2020 техникийн нөхцлийг МХС ТӨХК-ий Ховд аймаг дахь салбараас гаргуулан авч, зураг төслийг техникийн нөхцөлд заасны дагуу мэргэжлийн байгууллагаар зураг төслийг боловсруулан, холбогдох зөвшөөрлүүдийг авсан. Ажлын тоо хэмжээ, зардлыг нэгдсэн төсөвт тусгасан.

Газар хөдлөлтөөс үзүүлэх нөлөөллийг тооцох,

- ✓ Замын трасс, далан болон ус зайлуулах төмөрбетон хоолойн хийцийн сонголтыг “Газар хөдлөлтийн бүс нутагт барилга төлөвлөх БНбД 22.01.01*/2006/”-г ашиглан төлөвлөсөн.

Шинээр төлөвлөх авто замын хөдөлгөөн зохион байгуулалтыг оновчтой төлөвлөх,

- ✓ MNS 4596:2014 “Авто замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио, хашилт, чиглүүлэх хэрэгслүүдийг хэрэглэх дүрэм”, MNS 4597:2013 “Авто замын тэмдэг. Техникийн

ерөнхий шаардлага", MNS 4759:2013 "Авто замын тэмдэглэл. Техникийн ерөнхий шаардлага" болон Монгол улсын замын хөдөлгөөний дүрэм-ийн дагуу Хөдөлгөөн зохион байгуулалтын зургийг боловсруулсан.

Ухмал ба зам дээр цас хунгарлах, далан усанд автахаас сэргийлж далангийн шийдлийг төсөллөх,

- ✓ Дагуу төлөвлөлтийг гүйцэтгэхдээ замын орчны ус зүй, гадаргын байдал, уур амьсгал, цаг уурын нөхцөл байдал зэрэгт тулгуурлан төлөвлөсөн. Түүнчлэн цас хунгарлах, далан усанд автахаас сэргийлж зарим байршилд хажуугийн шуудуу татсан.

Мал амьтны зам хөндлөн гарах магадлал бүхий цэгүүдийг судалгаагаар тогтоож, мал амьтан авто замыг хөндлөн гарах гарц төлөвлөх,

- ✓ Талбай дээрх судалгаагаар мал амьтан зам хөндлөн гарах 2 байрлал тодорхойлогдсон бөгөөд тус байрлалд дагуу төлөвлөлтийг нам төсөллөж, "Мал тууж гарах газар" тэмдгийг замын 2 талд тавьсан.

Хөдөлгөөний аюулгүй байдлын дүгнэлт гаргах, тэмдэг, тэмдэгжилтийн талаар холбогдох стандартыг мөрдөх, холбогдох байгууллагаас санал авах, замын хөдөлгөөнийг зохион байгуулах техник хэрэгсэл, тоноглолыг оновчтой төлөвлөх,

- ✓ Хөдөлгөөн зохион байгуулалт болон Тоноглолын зургийг ШУТИС-ийн МИС-ийн багш, Замын хөдөлгөөн зохион байгуулалтын инженер А.Эрдэнэтуяагаар хянуулж, хөдөлгөөний аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан.

Замын барилгын ажлын явцад тээврийн хөдөлгөөнийг саадгүй явуулах түр замын ажлын хэмжээг гаргаж, зураг төсөвт тусгах,

- ✓ Түр зам байгуулах ажлын хэмжээг гаргаж, "3.4.1. Замын ажлын тоо хэмжээ, тодорхойлолт" бүлэгт үзүүлэв.

А0305 дугаартай улсын чанартай Ховд-Өлгий чиглэлийн авто замаас Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын чиглэлд хатуу хучилттай авто зам барих инженерийн нарийвчилсан зураг төслийг энэ даалгаварт дурьдагдсан техникийн үзүүлэлтээр шинэчлэн өөрчлөх, магадлалаар дахин баталгаажуулах,

- ✓ ЗТХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга баталсан 01/21 дугаар бүхий "А0305 дугаартай улсын чанартай Ховд-Өлгий чиглэлийн авто замаас Ховд аймгийн Эрдэнэбүрэн сум чиглэлийн хатуу хучилттай авто замын инженерийн нарийвчилсан зураг төсөлд өөрчлөлт оруулах ажлын даалгавар" гарсан учир хамаарахгүй.

ХОЁР. ХАЙГУУЛ СУДАЛГАА

2.1. УУР АМЬСГАЛ, ЦАГ УУРЫН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Судалгааны талбайн уур амьсгалын үзүүлэлтийг "Авто замын уур амьсгал, геотехникийн нөхцөл" (АЗУАГН 01.01-2004)-ийн үзүүлэлтээр өглөө.

Судалгааны зурвас нутаг дэвсгэр нь байрлалаар дэлхийн бөмбөрцөгийн хойт хагаст багтдаг учир эх газрын эрс тэс уур амьсгалтай байдаг.

Судалгааны талбай нь Монгол орны авто замын уур амьсгалын бүсчлэлээр Өндөр Уулын бүсийн Алтайн дэд (IB) уур амьсгалын бүсийн Нэн хүйтэн-чийглэг сэрүүн хахир дэд бүсэд хамаарах тогтвортой цасан бүрхүүл эрт тогтож, хожуу ханзардаг, хур бороо, аадар бороо, аянга цахилгааны эрчимтэй, газар хөдлөлтийн 6-9 баллтай юм.

Хүснэгт-2.1.1 Авто замын уур амьсгалын улирлын үргэлжлэх хугацаа

Дэд бүс	Өвөл			Хавар		Зун		Намар
	эхлэх	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	дуусах	үргэлжлэх хоног	үргэлжлэх хоног
IB	13-24.X	9-13.IY	167-191 /175/	15-16.IY	36-68 /51/	18.YIII-10.IX	65-121 /94/	44-61 /51/

Хүснэгт-2.1.2 Хөрс агаарын температурын үзүүлэлт

Дэд бүс	Хөрсний гадаргын температур, ^{0}C				Агаар орчины дундаж температур, ^{0}C		
	Олон жилийн дундаж	Хамгийн халуун	Хамгийн хүйтэн	0^0C нэвчих гүн, см	Олон жилийн дундаж	Хамгийн хүйтэн сарын	Хамгийн дулаан сарын
IB	-3...-5	55-60	-44...-49	>400	< -4	< -25	10...15

Хүснэгт-2.1.3 Хөрсний хөлдөлт-гэсэлтийн уур амьсгалын хугацаа

Дэд бүс	хөлдөлт			гэсэлт		
	эхлэх	дуусах	хоног	эхлэх	дуусах	хоног
IB	10.X-с эрт	10.YI-с хожуу	220-с олон	20.IY-с хожуу	1.YII	80

Хүснэгт-2.1.4 Монгол орны автозамын бүсүүдийн хөрсний хөлдөлтийн норматив гүн

Дэд бүс	Хөрсний хөлдөлтийн норматив гүн, м			
	Шавар, шавранцар	Элсэнцэр, тоосорхог элс	Дунд зэргийн элс, хайргархаг элс	Том хэмхдэст хөрс
IB	2,5	3,0	3,2	3,5

ХҮСНЭГТ-2.1.5 АВТО ЗАМЫН УУР АМЬСГАЛЫН ЖИЛИЙН 4 УЛИРЛЫН САЛХИНЫ ХУРД, АГААРЫН даралт, харьцангуй чийгшил

Дэд бүс	Салхины хурд, м/с				Даралт, мм Hg баганын өндөрөөр	Харьцангуй чийгшил, %
	өвөл	хавар	зун	намар		
IB	1-2	1.3-4.0	1-1.3	1-2	<550	60-70

Хүснэгт-2.1.6 Авто замын уур амьсгалын бүсүүд дах хур тунадасны хэмжээ, мм

Дэд бүс	Хур тунадасны нийлбэр, мм							
	өвөл	хавар	зун	намар	жил	1 хоногт орох борооны хангамж, мм		Борооны хамгийн их орох эрчим, мм/мин
						2%	1%	
IB	5-10	10-20	80-140	10-30	150-300	90	120	0.5-1.5

Хүснэгт-2.1.7 Аянга, дуу цахилгаан

Дэд бүс	Нийт аянгын үйлчлэл		Нэг аянгын	
	Өдрийн тоо	үргэлжлэл, цаг	үргэлжлэл, минут	1 км^2 талбайд ниргэх тоо
IB	25-30	40-50	90-100	6-7

Хүснэгт-2.1.8 Нойтон цас, хялмаа, мөстлөг

Дэд бүс	Нойтон цастай		Хялмаатай		Мөстлөгтэй		
	Өдрийн тоо	Үргэлжлэх, цаг	Өдрийн тоо	Үргэлжлэх, цаг	Өдрийн тоо	Зузаан, мм	
						10 жилд	5 жилд
IB	9-10	3-5	5-10	10-15	>2	20	15

Хүснэгт-2.1.9 Газрын гадрага дээрх цасны ачаалал

Дэд бүс	Цасны ачаалал, кг/м^2
IB	>70

2.2. ЗАМЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

Тухайн орчны замын өнөөгийн байдал. Төслийн зам нь Ховд аймгийн Ховд сумын нутаг дэвсгэрт байрлана.



Зураг 2.2.1. А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто зам

Ховд-Баян-Өлгий чиглэлийн А0305 дугаартай авто замын 23.15 дахь км-ээс эхлэн баруун урагш чиглэн Ховд сумын төвийн цементобетон хучилттай замын төгсгөлөөс цааш 73 м-т хүрнэ.

Замын эхлэлийн одоо байгаа А0305 дугаартай асфальтобетон хучилттай замын хучилтын өргөн нь 7м, хөвөөний өргөн нь 1.56м~1.73м, далангийн өргөн 10.29м~10.30м байна. Замын төгсгөлийн цементобетон хучилттай замын хучилтын өргөн 6.96 м, бетон хашлагатай, явган хүний замгүй. Цементбетон замын хучилтын гадаргуу элэгдэж, тэгш бус байдал үүссэн, дагуу заадас хэв гажилтанд орж төвшиний зөрүүтэй болсон байна.

Замын 13.1км, 18км - 18.28км хооронд хад асга, бул чулуутай. Замын дагууд алдаг оног хирэгсүүр үзэгдэнэ. Төслийн замтай 3 цэгт холбооны шилэн кабель шугам, 1 цэгт цахилгаан дамжуулах агаарын шугам хөндлөн гарна. Замын 11.7км-13.1км хооронд цахилгаан дамжуулах агаарын шугам, 10.9 км-17.5км, 18.3км-18.76км хооронд мэдээлэл холбооны шилэн кабель замын зүүн талаар дагууд үргэлжилнэ

Замын одоогийн байдлын фото зургийг дор үзүүлэв.

Зураг 2.2.2. Трассын эхлэл буюу Ховд –Баян-Өлгий чиглэлийн авто зам

Зураг 2.2.3. Замын трассын эхлэлээс 7 км орчимд шороон замын байдал

Зураг 2.2.4. Замын трассын 18 км-т шороон замын байдал

Зураг 2.2.5. Замын трасс хөндлөн гарч буй ЦДАШ, холбооны шилэн кабель

Зураг 2.2.6. Замын трассын дагууд байрлах хиргэсүүр

Зураг 2.2.7. Трассын төгсгөлийн цэг

2.3. БАЙР ЗҮЙН ЗУРАГЛАЛ

Трассын дагуух байр зүйн зураглалыг “Эрин кадастр” ХХК 2020 оны 12 сард хийж гүйцэтгэсэн.

А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын хайгуулын ажлын геодезийн хэмжилт, зураглалын ажлын хүрээнд дараах шаардлагатай хэмжилт, суурин боловсруулалтын ажлууд хийгдсэн.

Үүнд:

- Хуучин цэг, тэмдэгтийн судалгааны ажил;
- Шинэ цэг, тэмдэгтийн суулгалтын ажил;
- Геодезийн сүлжээний хэмжилт, боловсруулалтын ажил;
- Нивелирдлэгийн IV ангийн хэмжилт, боловсруулалтын ажил;
- Байр зүйн зургийн хээрийн хэмжилт, боловсруулалтын ажил.

Геодезийн хуучин цэг тэмдэгтийн судалгаа: Урьд жилүүдэд байгуулсан геодезийн сүлжээний цэгүүдэд үзлэг тооллого хийх, түүний бүрэн бүтэн байдал, ашиглах боломжийг ажлын явцад судлахаар Ховд аймгийн Ховд сумын 2014-2015 онуудад хийгдсэн “1:1000-ны масштабтай байрзүйн зургийн тодруулалт, шинэчлэлт хийх ажил”-ын GNSS-ийн зураглалын сүлжээний нийт 1 цэгийг ГЗБГЗЗГ-ын мэдээллийн төвөөс авч ашигласан.

Эдгээрээс ажлын шаардлага хангасан устаж гэмтээгүй, байрлалын хувьд төслийн талбайд ойрхон байгаа 1 цэгийн бүрэн бүтэн байдалд үзлэг хийж, хэмжилт хийх нөхцөл нь алдагдсан эсэхэд дүгнэлт өгч, байршлын тойм зураг шинээр үйлдэж, гэрэл зураг авах зэрэг ажил хийгдсэн. (Хүснэгт 2.3.1, Зураг 2.3.1).

Хүснэгт-2.3.1 Судалгаа хийж ашиглах цэг тэмдэгтийн солбицол

№	Цэгийн нэр, дугаар	Солбицол (WGS84, UTM46N)				Ашиглалтын байдал
		N_UTM	E_UTM	Өргөрөг	Уртраг	
1	ГЦТ-3267	5331550.930	379433.362	48°07’32.84397”	91°22’47.14300”	Хэвийн

Зураг 2.3.1. Судалгаа хийсэн цэгийн зураг

Цэгийн төв	Цэгийн орчны байдал
ГЦТ-3267	

Хээрийн судалгаагаар ажлын шаардлага хангасан төслийн талбайд байрлалын хувьд ойрхон 1 цэгт судалгаа хийж, үлдсэн 9 цэгийг шинээр суулгасан (Хүснэгт 2.3.2, Зураг 2.3.2).

Хүснэгт 2.3.2. Судалгаа болон шинээр суулгасан цэгүүд

№	Цэг, тэмдэгт		Нийт
	Судалгаа хийгдсэн	Шинээр суулгасан	
1	1	9	10

Шинээр суулгасан цэг, тэмдэгт: Шинээр геодезийн байрлал болон өндрийн цэгийн төв болон реперийг Монгол улсын барилгын дүрэм “Геодезийн байнгын цэг, тэмдэгт байгуулах ажил” БД11-104-06*/16 дагуу суулгасан. Геодезийн байнгын цэг, тэмдэгтийн төрлийг ажлын төрөл, нарийвчлал, газар орчны физик газарзүйн нөхцөл, хөрсний шинж чанарыг харгалзан сонгосон.

Төслийн талбайд шинээр суулгасан 9 цэгийн солбицол болон орон зайн байршлыг дараах Хүснэгт 2.3.3, Зураг 2.3.2-т тус тус үзүүлэв.

Хүснэгт 2.3.3 Шинээр суулгасан цэг тэмдэгтийн солбицол

№	Цэгийн нэр, дугаар	Солбицол (WGS84, UTM46N)			
		N_UTM	E_UTM	Өргөрөг	Уртраг
1	BM-1	5331316.599	379940.576	48°07’25.60234”	91°23’11.90890”
2	BM-2	5332031.303	381487.110	48°07’49.78538”	91°24’25.97949”
3	BM-3	5332115.112	384921.464	48°07’54.76798”	91°27’11.99893”

4	BM-4	5332851.342	386839.136	48º08’19.84345”	91º28’44.04587”
5	BM-5	5332095.162	388754.100	48º07’56.57564”	91º30’17.39070”
6	BM-6	5331721.154	390693.551	48º07’45.67580”	91º31’51.54382”
7	BM-7	5331918.858	392677.073	48º07’53.29255”	91º33’27.29929”
8	BM-8	5332636.791	394469.689	48º08’17.61792”	91º34’53.36485”
9	BM-61-5	5334144.755	396645.658	48º09’07.73104”	91º36’37.30993”

Зураг 2.3.2 Шинээр суулгасан цэг тэмдэгтийн орон зайн байршил

Геодезийн сүлжээний хэмжилт, боловсруулалт: Геодезийн сүлжээний хэмжилтийг SOUTH фирмийн GALAXY G1 хоёр долгионы GNSS-ийн хүлээн авагч ашиглан үндсэн сүлжээний цэгт тулгуурлан “STATIC” горимоор, хэмжилтийн нэг гурвалжинд 30 минутаас багагүй үргэлжлэх давхцалтай хугацааны нэг агшинд битүү полигон болгон хийж гүйцэтгэсэн. Схемийг Зураг 2.3.3-т үзүүлэв.

Зураг 2.3.3. GNSS-ийн сүлжээний хэмжилтийн схем



Нивелирдлэгийн IV ангийн хэмжилт, боловсруулалт: Төслийн талбайд ашиглагдах хуучин болон шинээр суулгасан сүлжээний цэгүүд дээр Балтийн тэнгисийн тогтолцоонд өндрийг тодорхойлохдоо ажлын талбайд ойр байгаа GNSS-ийн цэг дээр тулгуурлан нивелирдлэгийн III ангийн нарийвчлалаар өндрийн сүлжээний хэмжилт боловсруулалт хийсэн.

Нивелирдлэгийн хэмжилтийг Хятад улсын South фирмийн DL-202 маркийн 1 км нүүлтийн дундаж квадрат алдаа шууд урвууд 1.5 мм-ийн нарийвчлалтай компенсатортой нивелирээр 5 метрийн эвхдэг 2 рейкээр башмак ашиглан хийсэн.

Рейкнээс багаж хүртлэх хамгийн их зайг 100 метрээс хэтрүүлэхгүй бөгөөд утаа униар, зэрэглээ, салхигүй тогтуун байх үед нивелирдлэгийн хэмжилтийг хийж гүйцэтгэсэн. Нивелирдлэгийн III ангийн хэмжилтийг битүү сэлгэцийн аргаар шууд урвуу чиглэлд хийсэн.

Нүүлтийн зөвшөөрөгдөх алдааг томъёогоор тооцож, өндөржилтийн зөрүү зөвшөөрөгдөх хэмжээндээ байгаа $f_{h\,зөвш} = \pm 10 мм\sqrt{L}$ нөхцөлд засварыг зай, станцын тооноос хамааруулан тарааж өндрийг бодож гаргасан.

Энд *L* нь нүүлтийн уртыг км-ээр авсан тоо болно.

Байр зүйн зургийн хээрийн хэмжилт, боловсруулалт: Зураглалын ажлыг байрлал, өндрийн хувьд WGS-84 солбицлын тогтолцоо, UTM тусгаг, их хагас тэнхлэг 6378137 м, шахцал 1:298.25722101-г ашиглан балтын тэнгисийн өндрийн тогтолцоонд гүйцэтгэсэн. 1:1000-ны масштабтай, 0.5 метрийн үеийн өндөртэй байр зүйн зураглалын ажлыг хийсэн. Хээрийн хэмжилтийг GPS-ийн RTK горимоор хийж гүйцэтгэсэн.

Зураглалын ажлын хүрээнд дараах агуулгатайгаар 1:1000-ны масштабтайгаар хээрийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд:

- Зураглалын ажилд зориулан байгуулсан үндэслэлийн сүлжээний цэгүүдийг солбицолоор нь оруулах,
- Бүх төрлийн барилга байгууламж,
- Ус зүй түүний барилга байгууламж (доороосоо ундаргатай худаг, гол, булаг, нуур),
- Жалга, элс, дэрс дов намагны контур, нүх болон овоолсон шороо, шороон зам,
- Автомашины засмал зам, төмөр зам түүний барилга байгууламж буюу гүүр нүхэн гарц, гарам, нэгж талбарын хил болж байгаа явган хүний зам,
- Газар дээр байгаа 6 кВт ба түүнээс дээш өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах шугам, холбооны шугам, дулаан, цэвэр ус, хий дамжуулах хоолой зэрэг инженерийн барилга байгууламж,
- Газар дээр тодорхой орон зай эзэлж байгаа трансформатор, цагдаагийн байр, гарааш, хөшөөний цогцолбор, оршуулгын газар, шороон далан, ус түгээх байр, усан оргилуур,
- Гудамж талбайн нэр, хашаа болон байшингийн дугаар.

Байр зүйн ажлыг цэг, объект болон контурыг дүрслэн үзүүлэх нарийвчлал нь 0.1 м, өндөр тодорхойлох нарийвчлал нь 0.1 м-ээс ихгүй байх зарчмыг баримтлан ажилласан. Зураглалын ажлыг “Авто зам болон төмөр замын геодезийн ажил” БД 11-114-14, “Байр зүйн зургийн томъёолсон тэмдэг М1:5000, М1:2000, М1:1000, М1:500”-ийн дагуу хийж гүйцэтгэсэн. Байрзүйн зургийн зурагдах объектуудыг ангилал бүрээр нь тус тусад нь өөр өөр Layer-тэй оруулсан бөгөөд Layer-ийн нэр нь объектын ангиллын дугаар байна. Объектын ангиллын дугаар бүхий Layer-г (My layer) шинээр үүсгэхдээ Color > White, Linetype > Continuous, Lineweight > Default байдлаар сонгосон.

2.4. ЗАМЫН ДАГУУХ БУУРЬ ХӨРСНИЙ СУДАЛГАА

А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын инженерийн нарийвчилсан зураг төслийн шатанд инженер-геологийн судалгааг инженерийн геологийн судалгаа гүйцэтгэх тусгай зөвшөөрөл бүхий “БИГС” ХХК гүйцэтгэсэн болно.

Геологийн тогтоц

Судалгааны районы Геологийн тогтоцыг Дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар хучигдсан Палеозойн эх газрын тунамал-вулканоген чулуулгууд тодорхойлно.

1. *Палеозойн настай чулуулаг.* Бэсрэг уул, толгод үүсгэн тогтсон вулканоген чулуулаг. Энэ төрлийн чулуулагт боржин чулуу–хадан хөрс хамаарна.
2. *Дөрөвдөгчийн настай хурдас.* Татмын дээрх дэнжийн, бэсрэг уулын хажуугийн делюви-пролювийн хурдас. Энэ хурдсын найрлаганд элсэн болон элсэнцэр чигжээстэй хайрган хөрс зонхилно. Бул чулуутай.

Геоморфологи

Судалгааны зурвас талбайн хувьд эгц хажуу бүхий өндөр рельеф үүсгэх ба хөгжлийн хувьд энэ талбай тектоник-өргөгдлийн, зөөгдөл-хуримтлалын төрлийн рельефтэй бөгөөд гадаргын дүр төрхөд тектоник блокийн янз бүрийн хөдөлгөөн чухал үүрэг гүйцэтгэсэн. Тектоник хөдөлгөөнөөс гадна хурдас, чулуулгийн өөрийн физик, механик шинж чанар, рельефийн төрлүүдийг ялгах хүчин зүйл болж өгдөг.

Судалгааны зурвас нь рельеф гарал үүслээрээ нэгдүгээрт тектоник-өргөгдлийн гадаргуу, хоёрдугаарт зөөгдөл-хуримтлалын гадаргуу гэсэн 2 төрөлд хуваагдана. Үүнд:

1. Тектоник өргөгдлийн гадарга төрөл бүрийн үйл ажиллагааны улмаас хурдас чулуулгийн үүсгэсэн уул хад, цохио, дэл судал зэрэг нь эвдрэл бутралд орж эгц хажуу бүхий өндөр уулсыг үүсгэж тэр орчимдоо хадан гарш бүхий гадаргуу үүсгэсэн байна.

2. Зөөгдөл-хуримтлалын гадарга нь өндөрлөг гадаргуугийн хажуу, усны үйл ажиллагаа болон чулуулгийн хүндийн хүчний үйлчлэлээр явагдаж дээрх үүссэн бий болсон хурдас хуримтлалыг зөөж шилжүүлэн уулын бэл хормой болон бэсрэг хөндийн хурдсыг зузааруулж ерөнхийдөө тэгшрүүлэх байдлаар үүссэн байна.

Гидрогеологи

Судалгааны зурвас талбайн дагууд хөрсний ус илрээгүй бөгөөд зөвхөн зурвасын төгсгөл Ховд сумын төвд ПК-18+700-д өрөмдсөн цооногт хөрсний ус 2.0 метрийн гүнээс илэрч, 1.8 метр тогтсон байна. Химийн найрлага нь Гидрокарбонат-сульфат ангийн, магни-кальцийн бүлгийн, II төрлийн найрлагатай, саармаг орчинтой, эрдэсжилттэйвтэр хатуулаг ус болохын хамт бохирдолтыг тодорхйологч нэгдлүүд нилээд их илэрсэн бөгөөд “Бетон болон барилгын зуурмагт хэрэглэх ус техникийн нөхцөл”-ийг хангаж байгаа ба металл /Fe/ бүрхэвчтэй кабель утсанд нөлөөлөх боломж илэрч болно гэж тогтоогдсон байна.

Физик-геологийн үзэгдэл, үйл явц

Төлөвлөж буй авто замын зурвасын дагууд физик-геологийн үзэгдэл, үйл явц төдийлөн их хөгжөөгүй ба Монгол Алтайн нурууны салбар уулс бөгөөд хүрээлэн буй уулс нь шовх оргилуудтай, хажуу нь их эгц, хад асга элбэгтэй байдагтай холбоотойгоор нуранги,

асгарал хад элбэг тохиолдоно. Хур тунадасны усны нөлөөгөөр гэнэтийн үерт автах нөхцөлтэй байна.

<u>Олон жилийн цэвдэг</u>

Төлөвлөж буй авто замын зурвас нь олон жилийн цэвдэггүй бүслүүрт хамаарах бөгөөд өрөмдлөгөөр илрээгүй.

<u>Талбайн инженер-геологийн нөхцөл ба хөрсний физик-механик шинж чанар</u>

Судалгааны талбайд дагууд тархсан хөрс, чулуулгийн гарал үүсэл, шинж чанарыг харгалзан инженер-геологийн 4 элементэд ангилав. Үүнд:

- ИГЭ-1. Элсэн чигжээстэй хайрган хөрс
- ИГЭ-2. Элсэнцэр чигжээстэй хайрган хөрс
- ИГЭ-3. Хайргархаг шавранцар хөрс
- ИГЭ-4. Боржин чулуу - хадан хөрс

ИГЭ - 1. ЭЛСЭН ЧИГЖЭЭСТЭЙ ХАЙРГА

Элсэн чигжээстэй хайрган хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл /%/:

- хайрга	55.3
- элс	35.8
- тоос/шавар	8.9 тус тус агуулна.

Элсэн чигжээстэй хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл:

- байгалийн чийг	0.068
- эрдэслэг хэсгийн нягт, г/см^3	2.68
- байгалийн нягт, г/см^3	2.22
- хатуу хэсгийн нягт, г/см^3	2.08
- сүвшил, %	22.19
- сүвшлийн коэффициент	0.286
- чийглэгийн зэрэг	0.62

Элсэн чигжээстэй хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

Зууралдлын хүч	Схөрс=0.005 МПа
Дотоод үрэлтийн өнцөг	φхөрс=42^0
Хэв гажилтын модуль	Ехөрс=130 МПа
Тооцооны эсэргүүцэл /4/	Ro=6.0 кгх/см^2

Элсэн чигжээстэй хайрган хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад III байна.

Элсэн чигжээстэй хайрга нь АЗУАГН 2.01.01-2004-өөр сул овойлттой хөрсөнд нормчилогдоно.

ИГЭ - 2. ЭЛСЭНЦЭР ЧИГЖЭЭСТЭЙ ХАЙРГА

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл /%/:

- хайрга	57.0
- элс	31.7
- тоос/шавар	11.3 тус тус агуулна.

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл:

- байгалийн чийг	0.054
- урсалтын хязгаар дахь чийг	0.193
- имрэгдлийн хязгаарь дахь чийг	0.149
- уян налархайн тоо	0.045
- эрдэслэг хэсгийн нягт, г/см^3	2.70
- байгалийн нягт, г/см^3	2.22
- хатуу хэсгийн нягт, г/см^3	2.10
- сүвшил, %	22.21
- сүвшлийн коэффициент	0.286
- чийглэгийн зэрэг	0.51
- консистенц	<0

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

Зууралдлын хүч	Схөрс=0.045 МПа
Дотоод үрэлтийн өнцөг	φхөрс=32^0
Хэв гажилтын модуль	Ехөрс=108 МПа
Тооцооны эсэргүүцэл /4/	Ro=4.5 кгх/см^2

Элсэнцэр чигжээстэй хайрган хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад III байна.

Элсэнцэр чигжээстэй хайрга нь АЗУАГН 2.01.01-2004-өөр хүчтэй овойлттой хөрсөнд нормчилогдоно.

ИГЭ - 3. ХАЙРГАРХАГ ШАВРАНЦАР

Хайргархаг шавранцар хөрсний ширхэгийн бүрэлдэхүүний дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл /%/:

- хайрга	31.0
- элс	31.7
- тоос/шавар	37.3 тус тус агуулна.

Хайргархаг шавранцар хөрсний физик шинж чанарын үзүүлэлтийн дундаж утгыг лабораторийн шинжилгээний үр дүнгээр өгвөл:

- байгалийн чийг	0.175
- урсалтын хязгаар дахь чийг	0.208
- имрэгдлийн хязгаарь дахь чийг	0.123
- уян налархайн тоо	0.084
- эрдэслэг хэсгийн нягт, г/см^3	2.71
- байгалийн нягт, г/см^3	2.03
- хатуу хэсгийн нягт, г/см^3	1.73
- сүвшил, %	36.27
- сүвшлийн коэффициент	0.569
- чийглэгийн зэрэг	0.83
- консистенц	0.61

Хайргархаг шавранцар хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн норматив болон тооцооны утгыг АЗУАГН 2.01.01-2004-өөр өгвөл:

Зууралдлын хүч	Схөрс=0.008 кПа
Дотоод үрэлтийн өнцөг	φхөрс=11^0
Хэв гажилтын модуль	Ехөрс=27 МПа
Тооцооны эсэргүүцэл /4/	Ro=3.5 кгх/см^2

Хайргархаг шавранцар хөрсний газар шорооны ажлын зэрэг гэсгэлэн нөхцөлд гар аргаар малтахад III байна.

Хайргархаг шавранцар нь АЗУАГН 2.01.01-2004-өөр хэтэрхий овойлттой хөрсөнд нормчилогдоно.

ИГЭ - 4. БОРЖИН

Боржин чулууны шинж чанарын үзүүлэлтүүдийг өгвөл:

- байгалийн нягт, г/см^3
  - өгөршсөн 2.51
  - өгөршөөгүй 2.74

- өгөршлийн зэрэг 0.92
- нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, Rc, МПа 12
- газар шорооны ажлын зэрэг
  - өгөршсөн V
  - өгөршөөгүй VII
- овойлтгүй

Төлөвлөж буй авто замын зурвас нь инженер-геологийн дунд зэрэг нөхцөлтэй талбайд хамаарна.

Хүснэгт-2.4.1 Судалгааны зурвасын дагууд илэрсэн хөрсний механик шинж чанарын үзүүлэлтийн тооцооны утгыг хүснэгтээр үзүүллээ.

Хөрсний төрөл	Зууралдлын хүч, *кПа*	Дотоод үрэлтийн өнцөг, *градус*	Хэв гажилтын модуль, *МПа*	Тооцооны эсэргүүцэл
	$C_{ХӨРС}$	$Ф_{ХӨРС}$	$E_{ХӨРС}$	Ro, *кгх/см²*
Элсэн чигжээстэй хайрга /ИГЭ-1/	0.005	42	130	6.0
Элсэнцэр чигжээстэй хайрга /ИГЭ-2/	0.045	32	108	4.5
Хайргархаг шавранцар /ИГЭ-3/	0.008	11	27	3.5

Хүснэгт-2.4.2 Хадан хөрсний шинж чанарын үзүүлэлтүүд

Хөрсний төрөл	Байгалийн нягт, г/см³		Өгөршлийн зэрэг	Газар шорооны ажлын зэрэг		Хувийн цахилгаан эсэргүүцэл, Ом.м /лавлахаас/	Нэг чиглэлийн шахагдалд үзүүлэх түр зуурын эсэргүүцэл, Rc, МПа
	өгөршсөн	өгөршөөгүй		өгөршсөн	өгөршөөгүй		
Боржин /ИГЭ-4/	2.51	2.74	0.92	V	VII	50-600	12

Судалгааны зурвасын дагууд илэрсэн хөрсний газар шорооны ажлын зэрэг, хувийн цахилгаан /лавлахаас/ эсэргүүцэлийн /ом.м/ утгыг өгвөл:

- Элсэн чигжээстэй хайрга /ИГЭ-1/ - III - 2000-6000
- Элсэнцэр чигжээстэй хайрга /ИГЭ-2/ - III - 4500-7000
- Хайргархаг шавранцар /ИГЭ-3/ - III - 60-250

Хүснэгт-2.4.3 Судалгааны зурвасын дагууд илэрсэн хөрсний овойлтын зэрэг, үлгэрийн харьцангуй овойлтын утгыг хүснэгтээр үзүүллээ.

Хөрсний төрөл	Хөрсний бүлэг	Овойлтын зэрэг	Үлгэрийн харьцангуй овойлт, %
Элсэн чигжээстэй хайрга /ИГЭ-1/	II	Сул овойлттой	1-4
Элсэнцэр чигжээстэй хайрга /ИГЭ-2/	IV	Хүчтэй овойлттой	7-10
Хайргархаг шавранцар /ИГЭ-3/	V	Хэтэрхий овойлттой	>10
Боржин чулуу /ИГЭ-7/	-	Овойлтгүй	-

Хүснэгт-2.4.4 Судалгааны зурвасын дагууд илэрсэн хөрсний улирлын хөлдөлтийн гүнийг хүснэгтээр БНбД 50-01-16-аар үзүүллээ.

Хөрсний төрөл	Станц
	Ховд сум
Том хэмхдэст хөрсөнд /ИГЭ-1, 2, 3/	3,8м

Судалгааны зурвас талбай нь газар хөдлөлтийн /Ховд сум/ 9 баллын бүсэд хамаарна.

2.5. УС ЗҮЙН СУДАЛГАА, ТООЦОО

Судалгаанд хамрагдаж буй замын зурвас хэсэг нь Төв Азийн гадагш урсацгүй голуудын ай савд орших бөгөөд хаврын шар усны болон зуны хур борооны үерийн үед урсацтай болдог хуурай сайр жалга, хөндийг хөндлөн гарах ба эдгээр нь ус зүйн хувьд урьд өмнө судлагдаж байгаагүй болно.

Хээрийн судалгааны явцад замын зурвасыг байр зүйн зурагт буулгаж, сайр жалгын огтолж байгаа цэгүүдийг байршуулж, ус хураах талбайн ерөнхий байдал /ургамалшилт, хөрсний бүтэц, ус хураах талбайн өргөн, урт болон голдирлын тахиршилт, эргийн байдал зэрэг/-ын бичиглэл хийлээ.

Судалгаанд хамрагдаж байгаа замын хэсгийн төлөвлөж буй ус өнгөрөөх барилгуудын ус хураах талбайн сав газрын гидрографийн үзүүлэлт /ус хураах талбайн хэмжээ, дундаж өндөр, хэвгий болон сайр жалгын урт, дундаж хэвгий, тахиршилт/-ийг М1:100000 масштаб бүхий байр зүйн зураг ашиглан тодорхойлж гаргав.

Ус зүйн тооцоо

Судалгаанд хамрагдаж буй бүс нутагт “Усзүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм “/БНбД 2.01.14-86/ болон аман судалгаанаас үзэхэд зуны хур борооны үер нь хаврын шар усны үерээс илүү эрчимжилттэй байдаг тул хур борооны үерийн хамгийн их урсцын тооцоог гаргав. Хур борооны үерийн их урсцын тооцоог гаргахын тулд хоногийн хамгийн их тунадасны хангамшлын тооцоог хийв.

Хоногийн хамгийн их тунадас түүний хангамшил

Хоногийн хамгийн их тунадасны статистик боловсруулалтыг хийхийн тулд сав газарт ойрхон бөгөөд эгнээ нь урт байгаа Ховд, Өлгий станцуудын цаг уурын ажиглалтын материалаас хоногийн хамгийн их тунадсыг авч ашиглан үзүүлэв. Ажиглалтын эгнээнд моментын аргаар статистик боловсруулалт хийж, хангамшлын муруй байгуулан 1%-ийн хангамшил бүхий хоногийн хамгийн их тунадасны хэмжээг тооцон гаргахад Ховдод 81.9 мм, Өлгийд 72.5 мм тус тус байна.

Барилга байгууламжийн тооцоонд хэрэглэж байгаа (“Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд” /УЦУХ 1994 он/ хуудас136 зураг29)-д дурдсанаар хоногийн хамгийн их тунадасны 1%-ийн хангамж бүхий хэмжээг энэ бүсэд $H_{1\%}$=104,0мм гэж тодорхойлсноор цаашдын тооцоонд хамруулан хэрэглэв.

1%-ийн хангамж бүхий хоногийн хамгийн их тунадасны хэмжээний мужлал



“Барилгад хэрэглэх уур амьсгал ба геофизикийн үзүүлэлтүүд”

/УЦУХ 1994 он/ хуудас 136, 29-р зураг

Хамгийн их урсацын тооцоо

Тухайн сав газрууд нь Монгол орны уруйн үер эрчимтэй болж өнгөрдөг мужид хамаарагдах бөгөөд богино хугацаанд эрчимтэй орсон борооны улмаас их хурдтай үер бууж ирдэг онцлогтой. Иймээс судалгаагүй сав газрын /гол, горхи, хуурай сайр/ хур борооны үерийн усны хамгийн их урсацын тооцоог дараах аргачлалуудаар тооцож гаргав.

200 км^2-ээс бага ус хураах талбай бүхий гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсацын тооцоог (“Усзүйн тодорхойлолтуудыг тооцох норм ба дүрэм” /БНбД 2.01.14-86./)-д заасны дагуу хур борооны эрчимшилтийн аргыг ашигласан болно.

$$Q_{1\%} = q_{1\%} * \varphi H_{1\%} * \delta * p_{\%} * F$$

Энд: $Q_{1\%}$ - үерийн их урсац / м^3/с /

$q_{1\%}$ - үерийн их урсацын модуль / л/с км^2 /

φ - үерийн урсацын коэффициент

$H_{1\%}$ - 1% хангамжтай хоногийн хамгийн их тунадас / мм /

σ -нууршил, ой, намагшилтын коэффициент

$\lambda_{\%}$ - 1%-ийн хангамшлаас шилжүүлэх коэффициент

F - ус цуглуулах талбай / км^2 /

Урсацын хамгийн их модулийг ($q_{1\%}$-ийг) тодорхойлоход шаардагдах гулдрилын хэлбэр зүйн тодорхойлолт ($Ф_r$)-ийг дараах томъёогоор тодорхойлов.

$$Ф_r = 1000*L / K_r*J_r*F^{1/4}*(\varphi*H)^{1/4}$$

Энд: $Ф_r$ - голын хэлбэр зүйн тодорхойлолт

L - хөндлүүр хүртэлх гулдрилын урт /км/

K_r - гулдрил, татмын барзайлтын коэффициент

(“Усзүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм “/БНбД 2.01.14-86/2-ийн 15 дугаар хавсралтаас авна)

J_r - голын дундаж хэвгий

Ус цуглуулах талбайн хажуу бэлээр үер урсах хугацааг ($t_{хб}$) тодорхойлоход шаардагдах хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолт ($Ф_{хб}$)-ийг дараах томъёогоор тодорхойлов.

$$Ф_{хб} = (1000*L_{хб})^{1/2} / n_{хб}*J_{хб}^{1/4}*(\varphi*H)^{1/2}$$

Энд: $Ф_{хб}$ - хажуу бэлийн хэлбэр зүйн тодорхойлолт

$L_{хб}$ - ус цуглуулах талбайн хажуу бэлийн дундаж урт /км/

$J_{хб}$ - хажуу бэлийн дундаж хэвгий

$n_{хб}$ - хажуу бэлийн барзайлтын коэффициент

("Усзүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм "/БНбД 2.01.14-86/-ийн 23 дугаар хавсралтаас авна)

Үерийн урсацын коэффициентийг дараах томъёогоор тодорхойлов.

$$\varphi=C_2*\varphi_0/(F+1)^{n6}*(Jc*50)^{n5}$$

Энд: C_2 - эмпирик коэффициент (ойн бүсэд 1.3, бусад бүсэд 1.2-оор авна)

φ_0 - F=10 км^2, Jc=50% байх үеийн урсацын коэффициент

("Усзүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм "/БНбД 2.01.14-86/-ийн 21 дүгээр хавсралтаас авна)

n_5 - хөрсний бүтцээс хамаарах коэффициент

("Усзүйн тодорхойлолтуудыг тооцоолох норм ба дүрэм "/БНбД 2.01.14-86/-ийн 21 дүгээр хавсралтаас авна)

n_6 - уур амьсгалын бүсээс хамаарах коэффициент

(ойн бүсэд 0.07, бусад бүсэд 0.11-ээр авна)

200 км^2-ээс их ус хураах талбайтай гол горхи, сайруудын үерийн хамгийн их урсацыг редукцийн томьёо ашиглан гаргав.

$$Q_{1\%}=q_{1\%}*F=q_{200}*(200/F)^{0.5}*\delta_1*\delta_2*F$$

Энд: $Q_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их урсац

$q_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их урсцын модуль

q_{200} - 200км^2 талбайд тооцсон 1%-ийн магадлалыг давж гарах их урсцын модуль

δ_1 δ_2 - нууршил, ой, намагшилтын коэффициент

F - ус хураах талбай

Хамгийн их эгэл урсацын модулийн томьёо

$$Q_{1\%}=q_{1\%}*F=B_{1\%}/(F+1)^{0.4}*\delta_1*\delta_2*F$$

Энд: $Q_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их урсац

$q_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их урсцын модуль

$B_{1\%}$ - үерийн 1%-ийн хангамжтай их эгэл урсцын модуль

δ_1 δ_2 - нууршил, ой, намагшилтын коэффициент

F - ус хураах талбай

Эдгээр аргачлалуудаар тооцсон тооцооны үзүүлэлтүүдийг хүснэгтээр үзүүлэв.

Ус хураах талбайн зураг



Авто замын хоолойн усны тооцоо

№	Байрлал	F	L_r	J_r	$l_{хб}$	φ	$φH_{1\%}$	$Φ_{хб}$	Мужийн дугаар	$t_{хб}$	$Φ_r$	$q_{1\%}$	$Q_{1\%}$	$Q_{2\%}$	$Q_{5\%}$	Хоолойн хэмжээ
		(км²)	(км)	(‰)	(км)		(мм)			(мин)		(л/сек.км²)	(м³/сек)	(м³/сек)	(м³/сек)	(м)
1	1+000	2.607	1.430	13.99	1.82	0.09	9.79	28.23	2	400.00	29.60	0.0443	1.130	0.983	0.779	1.0x1.0
2	2+000	0.696	1.021	29.38	0.68	0.19	20.12	10.00	2	154.97	19.22	0.0567	0.794	0.691	0.548	1.0x1.0
3	2+600	0.696	1.021	29.38	0.68	0.19	20.12	10.00	2	154.97	19.22	0.0567	0.794	0.691	0.548	1.0x1.0
4	3+000	2.690	2.630	22.81	1.02	0.15	15.18	15.03	2	400.00	41.19	0.0365	1.491	1.297	1.029	1.0x1.0
5	4+400	0.737	2.070	38.65	0.36	0.25	25.71	5.97	2	62.58	33.00	0.0644	1.219	1.061	0.841	1.0x1.0
6	4+880	0.880	2.080	38.46	0.42	0.24	25.46	6.55	2	73.96	31.86	0.0624	1.397	1.216	0.964	1.0x1.0
7	5+240	0.880	2.080	38.46	0.42	0.24	25.46	6.55	2	73.96	31.86	0.0624	1.397	1.216	0.964	1.50x1.50
8	6+150	0.247	0.740	27.03	0.33	0.18	19.07	7.34	2	89.44	18.80	0.0735	0.346	0.301	0.239	1.50x1.50
9	6+400	5.442	4.347	23.00	1.25	0.14	14.71	16.85	2	400.00	57.38	0.0300	2.405	2.092	1.659	1.0x1.0
10	7+300	3.187	2.880	20.83	1.11	0.13	13.86	16.73	2	400.00	45.57	0.0348	1.536	1.337	1.060	1.0x1.0
11	9+850	1.011	0.843	23.72	1.20	0.16	16.40	15.50	2	400.00	16.32	0.0565	0.937	0.815	0.647	1.0x1.0
12	10+640	0.099	0.286	69.93	0.35	0.44	45.27	3.82	2	32.72	5.38	0.2000	0.896	0.780	0.619	1.0x1.0
13	11+120	0.115	0.308	64.94	0.37	0.41	42.31	4.19	2	37.60	5.81	0.1850	0.900	0.783	0.621	1.0x1.0
14	11+750	0.135	0.317	63.09	0.43	0.40	41.17	4.56	2	42.90	5.84	0.1729	0.961	0.836	0.663	1.0x1.0
15	12+500	0.100	0.593	101.18	0.17	0.61	63.13	2.06	2	12.56	9.07	0.2297	1.443	1.255	0.996	1.0x1.0
16	12+700	0.100	0.593	101.18	0.17	0.61	63.13	2.06	2	12.56	9.07	0.2297	1.443	1.255	0.996	1.0x1.0
17	12+990	0.074	0.475	105.26	0.16	0.63	65.52	1.93	2	11.48	7.65	0.2608	1.265	1.100	0.873	1.0x1.0

№	Байрлал	F	L_r	J_r	$l_{хб}$	φ	$φH_{1\%}$	$Φ_{хб}$	Мужийн дугаар	$t_{хб}$	$Φ_r$	$q_{1\%}$	$Q_{1\%}$	$Q_{2\%}$	$Q_{5\%}$	Хоолойн хэмжээ
		(км²)	(км)	(‰)	(км)		(мм)			(мин)		(л/сек.км²)	(м³/сек)	(м³/сек)	(м³/сек)	(м)
18	**13+260**	***0.074***	***0.445***	112.36	0.17	0.67	69.48	1.90	2	11.30	6.91	0.2758	***1.418***	***1.234***	***0.979***	***1.0x1.0***
19	**13+380**	***0.287***	***0.700***	100.00	0.41	0.59	61.78	3.26	2	25.36	8.29	0.1950	***3.457***	***3.007***	***2.385***	***1.0x1.0***
20	**14+000**	***0.460***	***0.791***	88.50	0.58	0.53	54.86	4.25	2	38.45	8.93	0.1554	***3.921***	***3.412***	***2.706***	***1.50x1.50***
21	**16+000**	***0.190***	***0.225***	44.44	0.84	0.29	29.94	8.23	2	107.46	4.63	0.0993	***0.565***	***0.491***	***0.390***	***1.0x1.0***
22	**16+740**	***0.057***	***0.172***	58.14	0.33	0.37	38.45	4.25	2	38.54	4.11	0.2063	***0.452***	***0.393***	***0.312***	***1.0x1.0***
23	**17+040**	***0.451***	***0.771***	77.82	0.58	0.47	48.89	4.66	2	44.22	9.40	0.1412	***3.113***	***2.708***	***2.148***	***1.50x1.50***
24	**17+680**	***0.107***	***0.368***	95.11	0.29	0.57	59.68	2.83	2	20.27	5.72	0.2528	***1.614***	***1.404***	***1.114***	***1.0x1.0***
25	**17+848**	***0.061***	***0.304***	115.13	0.20	0.68	71.09	2.05	2	12.52	4.89	0.3143	***1.363***	***1.186***	***0.940***	***1.0x1.0***
26	**18+180**	***0.083***	***0.318***	110.06	0.26	0.66	68.16	2.42	2	16.17	4.86	0.2951	***1.669***	***1.452***	***1.152***	***1.50x1.50***
27	**18+590**	***12.379***	***5.680***	21.13	2.18	0.12	12.94	24.21	2	400.00	64.82	0.0276	***4.414***	***3.840***	***3.046***	***2.00x1.50***

2.6. ИНЖЕНЕРИЙН ШУГАМ СҮЛЖЭЭНИЙ СУДАЛГАА

А0305 дугаартай улсын чанартай Ховд - Баян-Өлгий чиглэлийн авто замаас Ховд сум чиглэлийн хатуу хучилттай 18.755 км авто замын трасстай шугам сүлжээний огтлолцсон байдлыг хүснэгт 2.6.1-д үзүүлэв.

Хүснэгт-2.6.1 Замын трасс болон шугам сүлжээний огтлолцол

№	Шугам сүлжээний төрөл	Байршил км	Тайлбар
1	Цахилгааны шугам	18+661.7	Нам хүчдэл
2	Холбооны шугам	1+228.6	Шилэн кабель
3	Холбооны шугам	18+429.3	Шилэн кабель /трассын дагууд орсон/
	Холбооны шугам	18+487.4	
4	Холбооны шугам	18+643	Шилэн кабель /трассын дагууд орсон/
	Холбооны шугам	18+695	

ГУРАВ. ИНЖЕНЕРИЙН НАРИЙВЧИЛСАН ЗУРАГ ТӨСӨЛ

3.1. ЗАМЫН ТӨСӨЛЛӨЛТ

3.1.1. Стандарт шалгуур үзүүлэлтүүд, тооцоот сонголтууд.

Энэхүү замыг төлөвлөхөд мөрдөгдөх төлөвлөлтийн шалгуур, стандарт үзүүлэлтүүдийг “Авто зам төсөллөх ЗЗБНбД 22-004-2016” норм дүрмийг үндэслэн тогтоосон ба тус стандартын дагуу “ЗБ-ХОЗ-БХ-1-40” төсөллөлтийн зэрэглэлд хамааруулж сонгов.

Тооцоот хурдны сонголт.

ЗБ-ХОЗ-БХ-1-40. Энэ зам нь “Хөдөө орон нутгийн, байнгын хөдөлгөөнтэй зам. Хөдөлгөөний 1 зурвастай, тооцоот хурд нь 40 км/цаг” бүхий нийтийн хэрэглээний авто зам юм.

Төслийн замын хувьд тооцоот хурдын шаардлагуудыг хангахуйц төлөвлөлтийн шийдлүүд хийгдсэн болно.

Тооцоот хурдыг төслийн замын байр зүйн судалгаа, газар зүй, газрын ашиглалт зэрэгтэй нягт уялдуулан дараах зарчмаар сонгосон:

3.1.1.1. Тооцоот хурдыг орон нутгийн замд 40 км/цагаас багагүй байх нөхцлийг хангах геометр элементүүдийг сонгож төлөвлөлт хийгдлээ.

3.1.1.2. Мөн дараах нэмэлт арга хэмжээг төсөллөв.

- Замын дагууд өмнөх тээврийн хэрэгслийг харах, шаардлагатай тохиолдолд автомашины хөдөлгөөнийг хурдыг сааруулах зориулалтын үзэгдэх зайг нормын хэмжээнд хангах
- Орц, гарц, авто машины зогсоолын талбайг төлөвлөсөн болно.

Тооцоот хугацаа. Төслийн замын төсөллөлтийн тооцоот хугацааг (төсөллөлтийн жил)

- Орон нутгийн замд 10-15 жилээр тооцов.

Авто замын хөдөлгөөний үйлчилгээний төвшин (ХҮТ). Хөдөлгөөний үйлчилгээний төвшинг дараах гурван үзүүлэлт дээр суурилан тодорхойлдог:

- Аяллын дундаж хурд;
- Цаг зарцуулалтын хувь;
- Замын ашиглалт.

Тухайн замд орчны нөхцөлд тохирох, бодитой хамгийн дээд зэргийн үйлчилгээний төвшинг хангахыг хичээж, төлөвлөлтийг хийв. Монгол улсад мөрдөгдөж буй авто замын төлөвлөлтийн норм ба дүрмийн дагуу нийтийн зориулалттай замын сүлжээн дахь гол

